



ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ ИРГЭНД ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ ТҮР ЖУРАМ

**Улаанбаатар хот
2014 он**

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 9 дүгээр
сарын 27-ны өдөр

Дугаар 87

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.7, 48.10, Монголын Хуульчдын холбооны дүрмийн 4.6 дугаар зүйлийн 4, 4.10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус удирдлага болгон Хуульчдын холбооны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1.1 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1, Монголын Хуульчдын холбооны дүрмийн 4.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн “Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх түр журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү тогтоолыг 2014 оны 9 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ

Д.БАТСҮХ

АГУУЛГА

| | |
|--------------------|--|
| Нэгдүгээр бүлэг. | Нийтлэг үндэслэл 4 |
| Хоёрдугаар бүлэг. | Хууль зүйн туслалцаа үзүүлэх зарчим, хууль зүйн туслалцааны төрөл 4 |
| Гуравдугаар бүлэг. | Өргөдөл, хүсэлт хүлээн авах, төлбөрийн чадваргүй байдлыг тодорхойлох 5 |
| Дөрөвдүгээр бүлэг. | Өргөдөл, хүсэлтийг хуульчид хуваарилах 5 |
| Тавдугаар бүлэг. | Хуульчийн эрх, үүрэг 5 |
| Зургадугаар бүлэг. | Бусад зүйл 6 |

ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ ИРГЭНД ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ ТҮР ЖУРАМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 дүгээр зүйл.Журмын зорилго

1.Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх түр журам /цаашид “журам” гэх/-ын зорилго нь Төлбөрийн чадваргүй иргэнээс тодорхой төрлийн хууль зүйн асуудлаар туслалцаа авахаар ирүүлсэн өргөдөл, хүсэлтийг хүлээн авах, Монголын Хуульчдын холбоо /цаашид “Холбоо” гэх/-ний гишүүн, хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх эрх бүхий хуульчид хуваарилах, төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2 дугаар зүйл.Журмын үйлчлэх хүрээ

1.Хуульч нь эрүүгийн хэргийн хохирогч, захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч зэрэг төлбөрийн чадваргүй иргэнд энэ журамд заасны дагуу хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй эсхүл бага хөлсөөр үзүүлэх бөгөөд төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид үзүүлэх хууль зүйн туслалцаанд энэ журам хамаарахгүй.

2.Энэхүү журмаар зохицуулаагүй харилцааг Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Монголын Хуульчдын холбооны дүрэм, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмээр тус тус зохицуулна.

3.Шүүгч, прокуророор томилогдон ажиллаж байгаа хуульчид энэ журам хамаарахгүй.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ ЗАРЧИМ, ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦААНЫ ТӨРӨЛ

2.1 дүгээр зүйл.Хууль зүйн туслалцаа үзүүлэх зарчим

1.Хуульч нь төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэхдээ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль болон Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэмд заасан зарчмаас гадна дараах зарчмыг баримтална:

1.1.хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн хамгаалж, шударга ёсыг хангах;

1.2.шуурхай, бүрэн, тууштай, бодитой байх;

1.3.нууцыг чанд хадгалах;

1.4.хуульч нь төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх ажлыг бусад ажил үүргээсээ ялгаварлалгүй байдлаар хэрэгжүүлж, мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх;

1.5.хуульд харшлахгүй арга хэрэгслээр хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах.

2.2 дугаар зүйл.Хууль зүйн туслалцааны төрөл

1.Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн асуудлаар амаар болон бичгээр зөвлөгөө өгөх, эвлэрүүлэн зуучлах, өргөдөл, гомдол, хүсэлт, нэхэмжлэл, тайлбар бичих;

2.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөгч, өмгөөлөгчөөр оролцох;

3.Эрүүгийн байцаан шийтгэх болон захиргааны зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөгч, өмгөөлөгчөөр оролцох;

4.Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д заасан нөхцөл шаардлагын дагуу төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ӨРГӨДӨЛ, ХҮСЭЛТ ХҮЛЭЭН АВАХ, ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ БАЙДЛЫГ ТОДОРХОЙЛОХ

3.1 дүгээр зүйл.Өргөдөл, хүсэлтийг хүлээн авах, бүртгэх

1.Хууль зүйн туслалцаа хүсч буй төлбөрийн чадваргүй иргэний өргөдөл, хүсэлтийг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу Монголын Хуульчдын холбооны Тамгын газар /цаашид “Тамгын газар” гэх/ хүлээн авч бүртгэнэ.

2.Тамгын газар нь төлбөрийн чадваргүй байдлыг нотолсон баримт, нотолгоог шалган үзэж, өргөдөл, хүсэлтийг хүлээн авахаас татгалзах, хуульчид хуваарилах асуудлыг ажлын 3 өдрийн дотор шийдвэрлэнэ.

3.2 дугаар зүйл.Төлбөрийн чадваргүй байдлыг тодорхойлох

1.Хууль зүйн туслалцаа хүсч буй төлбөрийн чадваргүй иргэн нь төлбөрийн чадваргүй байдлаа өөрөө нотлох бөгөөд өргөдөл, хүсэлтдээ энэ талаарх баримт, нотолгоог хавсаргаж ирүүлнэ.

2.Тамгын газар нь хууль зүйн туслалцаа хүсч буй иргэний төлбөрийн чадваргүй байдлыг тодорхойлохдоо Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасныг баримтална.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ӨРГӨДӨЛ, ХҮСЭЛТИЙГ ХУУЛЬЧИД ХУВААРИЛАХ

4.1 дүгээр зүйл.Өргөдөл, хүсэлтийг хуульчид хуваарилах

1.Төлбөрийн чадваргүй байдал нь хангалттай нотлогдсон нөхцөлд тухайн иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх боломжтой эсэх талаар Про-боно үйлчилгээний чиглэлээр байгуулагдсан сайн дурын хороогоор дамжуулан ийм төрлийн үйл ажиллагаа явуулдаг хуульчид санал болгоно.

2.Энэ журмын 4.1 дүгээр зүйлийн 1-д заасны дагуу шийдвэрлэх боломжгүй болсон нөхцөлд төлбөрийн чадваргүй иргэний өргөдөл, хүсэлт, хуульчдын нэгдсэн бүртгэлд дэх хуульчийн мэргэшсэн салбарыг нь харгалзан цагаан толгойн үсгийн дарааллаар хуульчдад хуваарилна.

ТАВДУГААР БҮЛЭГ ХУУЛЬЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

5.1 дүгээр зүйл.Хуульчийн эрх

1.Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэхээр ажиллаж байгаа хуульч Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль болон хууль тогтоомжид заасан эрхээс гадна дор дурдсан эрх эдэлнэ:

1.1.төлбөрийн чадваргүй иргэнд туслалцаа үзүүлэх талаар Холбооноос хуваарилсан өргөдөл, хүсэлт нь тухайн тохиолдол /тодорхой хэрэг, маргаан/-д ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй байвал хүлээн авахаас татгалзах;

1.2.төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлын явцад тухайн үйлчлүүлэгч төлбөрийн чадвартай болох нь илэрхий болсон, төлбөрийн чадваргүй байдлаа нотлох баримтыг хуурамчаар бүрдүүлсэн нь тогтоогдсон тохиолдолд хууль зүйн туслалцаа үнэ төлбөргүй үзүүлэхээс татгалзах;

1.3.хуульчийн өгсөн зөвлөгөөг хүлээн авахаас татгалзсан, хууль бус шаардлага тавьсан тохиолдолд тухайн иргэнд туслалцаа үзүүлэхээс татгалзах.

5.2 дугаар зүйл.Хуульчийн үүрэг

1.Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэхээр ажиллаж байгаа хуульч Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль болон хууль тогтоомжид заасан үүргээс гадна дор дурдсан үүрэгтэй:

1.1.төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлын явцын тайланг улирал тутамд, дууссан хэргийн талаарх тайланг ажиллаж дууссанаас хойш 1 сарын дотор Тамгын газарт хүргүүлэх;

1.2.хууль зүйн туслалцаа үзүүлж буй төлбөрийн чадваргүй иргэнтэй хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулж ажиллах;

1.3.төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх явцад хуульчийн өгсөн зөвлөгөөг хүлээн авахаас татгалзсан, хууль бус шаардлага тавьсан тохиолдлыг баримтжуулах.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

6.1 дүгээр зүйл.Санал, гомдлыг шийдвэрлэх

1.Төлбөрийн чадваргүй иргэнд туслалцаа үзүүлэх ажлын хүрээнд хуульчийн үйл ажиллагаатай холбоотой гарсан санал, гомдлыг Холбоо ердийн журмаар хүлээн авч шийдвэрлэнэ.

6.2 дугаар зүйл.Журам хүчин төгөлдөр болох

1.Энэхүү журмыг 2014 оны 9 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.